

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 27 дугаар цэцэрлэг 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/92/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Дархан-Уул аймаг
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:
Утас: 70378845
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 70373089
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: З.Мөнгөнцэцэг
Утас: 70373089
Цахим хаяг: munguntsetsegz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
27 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ж.БАТЗАЯА ТАНАА

2025.02.05 № 81
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 27 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 13,408.5 мянган төгрөгийн компьютер, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 8,340.0 мянган төгрөгийн аяга таваг угаагч хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 537,145.2 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 40.5 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Дархан сумын 27 дугаар цэцэрлэгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 32 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 92 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	105,175,308.05	173,823,879.72
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	80,348,042.55	143,431,325.22
312	Банканд байгаа бэлэн мөнгө	80,348,042.55	143,431,325.22
3121	төгрөг		
31211	Төрийн сангийн харилцах		
33	АВЛАГА	-	-
332	Төлбөртэй үйлчилгээний авлага		
3351	Байгууллагаас авах авлага		
35	БАРАА МАТЕРИАЛ	24,827,265.50	30,392,554.50
351	Түүхий эд материал	-	-
3511	Тусгай зориулалттай материал		
3513	Эм боох материал		
354	Хангамжийн материал	24,827,265.50	30,392,554.50
35410	Бичиг хэргийн материал	487,800.00	543,300.00
35420	Аж ахуйн материал	1,693,500.00	1,580,000.00
3546	Хүнсний материал	4,704,945.50	5,774,634.50
35470	Бусад хангамжийн материал	17,941,020.00	22,494,620.00
36	НӨӨЦ БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,307,282,341.05	1,309,208,161.82
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,307,282,341.05	1,309,208,161.82
392	Биет хөрөнгө	1,169,482,341.05	1,171,408,161.82
39201	Барилга, байгууламж орон сууц	1,229,192,772.00	1,229,192,772.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(125,393,624.43)	(145,880,170.59)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	44,415,606.30	67,084,606.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,381,646.51)	(16,357,521.55)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,862,226.64	46,442,226.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,411,645.19)	(15,792,301.36)
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,129,800.00	12,776,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,931,147.76)	(6,057,849.62)
39217	Ном		
393	Биет бус хөрөнгө	137,800,000.00	137,800,000.00
39301	Программ хангамж		-
39302	Хуримтлагдсан элэгдэл		
39303	Бусад биет бус хөрөнгө	137,800,000.00	137,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,412,457,649.10	1,483,032,041.54
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,412,457,649.10	1,483,032,041.54
51	Засгийн газрын хувь оролцоо	1,412,457,649.10	1,483,032,041.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	137,800,000.00	137,800,000.00
51101	Өмч: - төрийн	137,800,000.00	137,800,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,274,657,649.10	1,345,232,041.54
51210	Өмнөх үеийн үр дүн	1,274,657,649.10	1,274,657,649.10
51220	Тайлант үеийн үр дүн		70,574,392.44
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,412,457,649.10	1,483,032,041.54



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	629,955,580.00	855,649,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,533,180.00	25,297,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	35,533,180.00	25,297,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	35,000.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,097,160.00	3,549,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө	23,319,800.00	21,748,500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	6,081,220.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	0.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	570422000	785953800
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	570422000	785953800
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,000,400.00	44,397,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	24,000,400.00	44,397,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	573,077,508.57	785,074,807.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	573,077,508.57	785,074,807.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	568,450,519.99	766,623,243.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	393,343,499.00	537,206,452.33
210101	Үндсэн цалин	270,214,214.24	352,571,958.33
210102	Нэмэгдэл	107,249,953.76	138,872,981.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,884,000.00	1,818,000.00
210104	Урамшуулал	13,995,331.00	18,926,300.00
210105	Гэрээт ажлын хөлс		25,017,213.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,528,609.77	74,356,100.00
210201	Тэтгэврийн даатгал	31,533,309.77	50,562,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,999,500.00	5,947,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,998,700.00	2,974,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,000,200.00	2,974,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,996,900.00	11,897,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,883,211.42	21,018,736.26
210301	Гэрэл, цахилгаан	5,865,731.94	7,034,578.06
210302	Түлш, халаалт	9,759,594.06	6,908,059.84
210303	Цэвэр, бохир ус	6,257,885.42	7,076,098.36
210304	байрны түрээс		



2104	Хангамж, бараа материалын зардал	4,322,100.00	7,422,700.00
210401	Бичиг хэрэг	3,337,400.00	7,016,800.00
210402	Тээвэр, шатахуун		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	128,700.00	257,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	856,000.00	148,500.00
210408	Бараа материал акталсны зардал		
2105	Нормативт зардал	58,677,568.50	65,388,276.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	121,350.00	123,390.00
210502	хоол хүнс	58,556,218.50	65,264,886.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	19,351,500.00
210601	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар		19,351,500.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,263,900.00	715,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар		
210805	тээврийн хэрэгслийн оношлогоо		
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,263,900.00	715,800.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,431,631.30	41,163,679.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,070,720.00	8,445,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	439,600.00	1,500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,921,311.30	31,218,279.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,626,988.58	18,451,563.74
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,809,800.00	14,572,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,809,800.00	14,572,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	817,188.58	3,879,163.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	817,188.58	3,879,163.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	56,878,071.43	70,574,392.44
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН		
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	56,878,071.43	70,574,392.44



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	594,457,400.00	830,351,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	35,000.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	24,000,400.00	44,397,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	570,422,000.00	785,953,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,000,400.00	44,397,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,000,400.00	44,397,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	545,264,278.77	759,421,817.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	545,264,278.77	759,421,817.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	540,637,290.19	740,970,253.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	382,389,708.77	537,145,252.33
210101	Үндсэн цалин	259,260,424.01	366,879,934.33
210102	Нэмэгдэл	107,249,953.76	121,207,805.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,884,000.00	1,818,000.00
210104	Урамшуулал	13,995,331.00	22,222,300.00
210105	Гэрээт ажлын хөлс		25,017,213.00
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,482,400.00	74,356,100.00
210201	Тэтгэврийн даатгалын	42,487,100.00	50,562,800.00
210202	Тэтгэмжийн даатгалын	4,999,500.00	5,947,600.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	3,998,700.00	2,974,300.00
210204	Ажилгүйдлийн даатгалын	1,000,200.00	2,974,300.00
210205	Эрүүл мэндийн даатгалын	9,996,900.00	11,897,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,883,211.42	21,018,736.26
210301	Гэрэл, цахилгаан	5,865,731.94	7,034,578.06
210302	Түлш, халаалт	9,759,594.06	6,908,059.84
210303	Цэвэр, бохир ус	6,257,885.42	7,076,098.36
210304	байрны түрээс		
2104	Хангамж, бараа материал	35,000.00	-
210401	Бичиг хэргийн зардал	35,000.00	
210402	Тээвэр шатахуун		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		




210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
2105	Нормативт зардал	54,888,870.00	66,395,775.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	хоол хүнс	54,888,870.00	66,395,775.00
2106	Эд хогшил урсгал засвар	1,300,000.00	19,500,000.00
210601	Багаж техник хэрэгсэл		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	1,300,000.00	19,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоодын томилолт		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	1,392,800.00	715,800.00
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,392,800.00	715,800.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,265,300.00	21,838,590.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,748,600.00	14,552,390.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	3,516,700.00	7,286,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,626,988.58	18,451,563.74
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,809,800.00	14,572,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,809,800.00	14,572,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	817,188.58	3,879,163.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	817,188.58	3,879,163.74
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	49,193,121.23	70,929,882.67
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	2,051,400.00	7,846,600.00
	Дотоод эх үүсвэр	2,051,400.00	7,846,600.00
222001	Тоног төхөөрөмж	2,051,400.00	2,620,000.00
223001	Бусад хөрөнгө		5,226,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(2,051,400.00)	(7,846,600.00)
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	47,141,721.23	63,083,282.67
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		80,348,042.55
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		143,431,325.22




2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	917,096,700.00	763,389,253.59	(153,707,446.41)	83.24
21	Урсгал зардлын дүн	917,096,700.00	763,389,253.59	(153,707,446.41)	83.24
210	Бараа үйлчилгээний зардал	902,524,300.00	748,816,853.59	(153,707,446.41)	82.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	661,772,000.00	537,145,252.33	(124,626,747.67)	81.17
210101	Үндсэн цалин	462,528,800.00	366,879,934.33	(95,648,865.67)	79.32
210102	Нэмэгдэл	187,546,200.00	121,207,805.00	(66,338,395.00)	64.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт		1,818,000.00	1,818,000.00	
210104	Урамшуулал	11,697,000.00	22,222,300.00	10,525,300.00	189.98
210105	Гэрээт ажлын хөлс	-	25,017,213.00	25,017,213.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,046,500.00	74,356,100.00	(2,690,400.00)	96.51
210201	Тэтгэврийн даатгал	52,393,200.00	50,562,800.00	(1,830,400.00)	96.51
210202	Тэтгэмжийн даатгал	6,162,200.00	5,947,600.00	(214,600.00)	96.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,081,800.00	2,974,300.00	(107,500.00)	96.51
210204	Ажилгүйдлийн даатгал	3,081,800.00	2,974,300.00	(107,500.00)	96.51
210205	ЭМД-ын хураамж	12,327,500.00	11,897,100.00	(430,400.00)	96.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,475,800.00	21,018,736.26	(11,457,063.74)	64.72
210301	Гэрэл, цахилгаан	11,477,600.00	7,034,578.06	(4,443,021.94)	61.29
210302	Түлш, халаалт	13,067,000.00	6,908,059.84	(6,158,940.16)	52.87
210303	Цэвэр, бохир ус	7,931,200.00	7,076,098.36	(855,101.64)	89.22
2105	Нормативт зардал	76,760,100.00	66,395,775.00	(10,364,325.00)	86.50
210501	Эм			-	
210502	Хоол хүнс	76,760,100.00	66,395,775.00	(10,364,325.00)	86.50
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл			-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,500,000.00	19,500,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	19,500,000.00	19,500,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал			-	
210702	Дотоод томилолт			-	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	2,464,700.00	715,800.00	(1,748,900.00)	29.04



210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,464,700.00	715,800.00	(1,748,900.00)	29.04
210807	Газрын төлбөр				
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,505,200.00	29,685,190.00	(2,820,010.00)	91.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,031,400.00	22,398,990.00	(2,632,410.00)	89.48
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,473,800.00	7,286,200.00	(187,600.00)	97.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,572,400.00	14,572,400.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,572,400.00	14,572,400.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	14,572,400.00	14,572,400.00	-	100.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	917,096,700.00	826,472,536.26	-	90.12
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	865,120,900.00	785,953,800.00	-	90.85
131001	Улсын төсвөөс санхүүжих	865,120,900.00	785,953,800.00	-	90.85
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	51,975,800.00	40,518,736.26	-	77.96
132001	Орон нутгийн төсвөөс	51,975,800.00	40,518,736.26	-	77.96
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		80,348,042.55		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		143,431,325.22		
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
3	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29.00	24.00	-	100.00
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
	Гүйцэтгэх ажилтан	19.00	16.00	-	100.00
	Үйлчлэх ажилтан	9.00	7.00	-	100.00



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн 27 дугаар цэцэрлэг нь Боловсролын талаарх төрийн бодлого, хууль тогтоомж шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажил зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааны удирдлага, менежментийн ажлыг сайжруулах, үр дүнг тооцох зорилго дэвшүүлэн ажилласан.

- Бодлогын баримт бичигт тусгагдах зорилтын хүрээнд
- Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд
- Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ
- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ зэрэг 4-н зорилт 3000 арга хэмжээний хүрээнд зорилт тавьж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Зардлын норматив шинэчлэн батлах тухай” 2021 оны А/188 дугаар тушаал, Хүүхэд хамгааллын тухай хууль болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын “Аргачлал, зардлын норматив батлах тухай” 2022 оны А/23,27 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоол “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоол “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоол “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 82 тоот тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 104 тоот тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш ажилтанд мөнгөн тэтгэмж олгох”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 237 тоот тогтоол “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”,
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны А/85, А/34 дүгээр тушаал “Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай”,
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны 115 тоот дугаар тушаал “Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх дүгнэх”

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн 27 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна. Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх НББ-ийн журам”-ыг үндэслэн 2025 оноос Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулж мөрдөж ажиллана.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн 27 дугаар цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 70,574.4 мянган төгрөгөөр буюу 5.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	80,348.00	143,431.30	63,083.30
Авлага	-	-	
Бараа материал	24,827.30	30,392.50	5,565.20
Үндсэн хөрөнгө	1,307,282.30	1,309,208.20	1,925.90
Нийт хөрөнгө	1,412,457.60	1,483,032.00	70,574.40
Өр төлбөр	-	-	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,412,457.60	1,483,032.00	70,574.40
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,412,457.60	1,483,032.00	70,574.40

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 143,431.3 мянган төгрөгийг үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 30,392.5 мянган төгрөг болж 5,565.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 95,235.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаандаа 89,670.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан зэргээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,309,208.2 мянган төгрөг болж 1,925.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2,620.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3,580.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,646.6 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө худалдан авч, БЕГ-аас 13,408.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж шилжүүлэн авсан, Дархан сумын ЗДТГ-аас 8,340.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авч, Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/16 тоот албан бичгийг үндэслэн 5,248.5 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож, дахин үнэлгээгээр 3,549.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж, тайлант онд 31,218.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал зэрэг нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,483,032.0 мянган төгрөг болж 70,574.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх нийт зарлагыг орон нутгийн төсвөөс 51,975.8 мянган төгрөг, улсын төсвөөс 601,454.8 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхдээ 785,953.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 51,975.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 785,953.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 722,870.4 мянган төгрөгийг зарцуулж, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 143,431.3 мянган төгрөгийн үлдэгдтэй, Орон нутгийн төсвөөс 44,397.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 40,518.7 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 3,879.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийн 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээнд 763,389.3 мянган төгрөг буюу 84.5 хувьтай байгаа нь төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэх хүрээнд урсгал зардлыг 143,431.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	81605	Эрүүл мэндийг дэмжих	2,209.2	1,079.0	(1,130.2)	48.8%
2	80233	Хүүхэд хамгаалал	1,180.9	1,180.9	-	100.0%
3	80111	Тогтмол зардал	44,397.9	40,518.7	(3,879.2)	91.3%
4	81807	Хүүхдийн хоол	76,760.1	66,395.7	(10,364.4)	86.5%
5	81823	Багш ажилдчын мэргэжил дээшлүүлэх	1,684.8	940.0	(744.8)	55.8%
6	81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	2,761.2	2,761.2	-	100.0%
7	81834	Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх	754,453.6	618,556.5	(135,897.2)	82.0%
8	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	33,649.0	31,957.3	(1,691.7)	95.0%
Нийт дүн			917,096.7	763,389.3	(153,707.5)	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14.7-д “Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална” гэж заасан заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус цэцэрлэг нь удирдах 2 ажилтан, гүйцэтгэх 7 ажилтан, үйлчлэх 15 ажилтан буюу нийт 24 ажилтантайгаар ажиллаж, 210901-Бараа үйлчилгээний бусад зардалд 13,281.8 мянган төгрөгийг зарцуулж, худалдан авах ажиллагаатай холбоотой гэрээ шууд байгуулахаар 21,481.5 мянган төгрөг, харьцуулалтын аргаар 56,983.8 мянган төгрөгийн ажил, үйлчилгээ төлөвлөж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч нэг оролцогч оролцоогүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн 27 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн 27 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 09 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 573,077.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,730.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Дархан Уул аймгийн 27 дугаар цэцэрлэгийн 2024 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд цалин хөлс нэмэгдэл урамшлын зардал 122,935.0 мянган төгрөг, ажил олгогчос төлөх НДШ 2,690.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,879.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,748.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 2,125.9 мянган төгрөг, хоол, хүнсний зардал 10,364.3 мянган төгрөг, багшийн мэргэжил дээшлүүлэх зардал 744.8 мянган төгрөг, эрүүл мэндийг дэмжих зардал 1,130.2 мянган төгрөгийн зардал тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс 169 мэдээллийг бүрэн байршуулж, хугацаа нь болоогүй 2 мэдээлэл, 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 75,316.8 төгрөгийн 12 гүйлгээний мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу “Ахмадын сан” байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар илэрсэн нийт 4,100.7 мянган төгрөгийн зөрчил илэрч 1 зөрчлийн биелэлтийг шалгахад зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	4,100.7	1	4,100.7	100
Нийт дүн	1	4,100.7	1	4,100.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр баталсан 601,454.8 мянган төгрөгийн төсвийн хуваарийг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 184,499.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 204,675.0 мянган төгрөг төвлөрсөн тул харилцах дансны үлдэгдэл өсөж төсвийн гүйцэтгэл 93.1 хувьтай гарсан байна. Иймд төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж, шийдэл гаргах нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 765.0 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж, аудитын явцад залруулав. Үүнд: Аудитаар өмчийн өөрчлөлтийн тайланд дахин үнэлгээний нэмэгдэл 765,0 мянган төгрөг тайлагнасаных аудитын явцад залруулав.

Аудитаар нийт 3,088.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгөв.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

5.2 Албан шаардлага

5.2.1.Илрүүлэлт: Тус цэцэрлэгийн эрхлэгч Ж.Батзаяаг Дархан-Уул аймгийн БГ-ын даргын А/141 тоот тушаалаар 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр “өөрчлөлтгүй” гэж дүгнэгдсэнд нэг сарын цалин 2 дахин нэмэгдүүлэн 3,088.0 мянган төгрөгийн балансын урамшуулал авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 тогтоолын “Төрийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-тай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Дээрх албан шаардлагын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж			
	Залуулсан		Залуулагүй		Залуулсан		Залуулагүй		Тоо		Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аудитаар өмчийн өөрчлөлтийн тайланд дахин үнэлгээний нэмэгдэл 765,0 мянган төгрөг тайлагнасанг аудитын явцад залруулав.	1	765.0	-	-	1	765.0	1	765.0	-	-	-	-
Дүн	1	765.0	-	-	1	765.0	1	765.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус цэцэрлэгийн эрхлэгч Ж.Батзаяаг Дархан-Уул аймгийн БГ-ын даргын А/141 тоот тушаалаар 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр "өөрчлөлтгүй" гэж дүгнэгдсэнд нэг сарын цалин 2 дахин нэмэгдүүлэн 3,088.0 мянган төгрөгийн балансын урамшуулал авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 тогтоолын "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-тай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлэв.	1	3,088.0	-	-	1	3,088.0	-	-	-	-
Дүн	1	3,088.0	-	-	1	3,088.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	1	-